



## УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 21

Улаанбаатар хот

### XXI ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын XXI хурал 2020 оны 5 дугаар сарын 03-ны өдрийн 16:00 цагт Төрийн ордны Шадар сайдын хурлын өрөөнд 100 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Ө.Энхтүвшин даргалж, холбогдох үүрэг, даалгаврыг өгөв.

#### ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Улсын онцгой комиссын шуурхай штабаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар

Шуурхай штабын дарга, Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга, хурандаа Б.Ууганбаяр

2. Мэргэжлийн болон бусад богино хугацааны танхимын сургалтын үйл ажиллагааг үе шаттайгаар нээх эсэх талаар

Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг

3. Нийслэлийн онцгой комиссоос авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар  
Нийлэлийн Засаг дарга бөгөөд  
Улаанбаатар хотын захирагч С.Амарсайхан

## ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзоригт:

1.1. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 139 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах, мэргэжлийн /богино хугацааны/ сургалт явуулж буй сургалтын төвүүдийн үйл ажиллагааг үе шаттайгаар нээх талаар санал боловсруулж Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлүүлэх;

1.2. Дээрхи асуудлаар Засгийн газрын хуралдаанаас сургалтын төвүүдийн үйл ажиллагааг нээх шийдвэр гарсан тохиолдолд Эрүүл мэндийн болон мэргэжлийн хяналтын байгууллагаас холбогдох зөвлөмжийг гаргуулан мөрдөж ажиллах;

Хоёр. Зам, тээврийн хөгжлийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Б.Энх-Амгалан,

Тагнуулын ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн Д.Гэрэл,

Цагдаагийн ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал С.Баатаржав:

3.1. Захиалгат нислэгээр БНСУ-аас бусад оронд байгаа гадаад улс орноос эх орондоо ирэх хүсэлтэй иргэдийг зохион байгуулалттайгаар татан авах үед зөрчил гаргаж, бусдад давуу байдал олгосон байж болзошгүй асуудлыг яаралтай судлан, холбогдох иргэн, хуулийн этгээд, албан тушаалтанд хууль, тогтоомжийн дагуу хариуцлага тооцох;

Гурав. Зам, тээврийн хөгжлийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Б.Энх-Амгалан,

Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар,

Улсын Онцгой комиссын орлогч дарга, Онцгой байдлын Ерөнхий газрын дарга

хошууч генерал Т.Бадрал нарт:

4.1. “Оюу толгой” ХХК-д ажиллаж буй гадаадын нарийн мэргэжилтэн, инженер техникийн ажилтнуудыг сэлгэн ажиллуулах ажлын зайлшгүй шаардлага, ирүүлсэн хүсэлтийг харгалзан Австрали Улс руу Үндэсний агаарын тээвэрлэгч “МИАТ” ХК-аар дамжуулан захиалгат нислэгийг ойрын хугацаанд үйлдэх, тус нислэгээр эх орондоо ирэх хүсэлтэй Монгол Улсын иргэдийг татан авчрах ажлын бэлтгэлийг ханган зохион байгуулах;

Дөрөв. Аймаг, Нийслэлийн Засаг дарга нарт:

2.1. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 147 дугаар тогтоолоор Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвслийг сонгуульд оролцох нэр дэвшүүлэх асуудлыг шийдвэрлэх намын Их Хурал эсхүл намын төлөөллийн төв байгууллагын хурлыг 2020 оны 5 дугаар

сарын 15, 16-ны өдрүүдэд зохион байгуулах нөхцөл боломжоор хангаж, Улсын Онцгой комиссоос коронавирусын халдвараас сэргийлэх талаар гаргасан зөвлөмжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах;

2.2. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээ зохион байгуулахыг хориглох;

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД,  
УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА



Ө.ЭНХТҮВШИН

УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.САНЖАА